



Брокер Дилер Андеррайтерийн Компани

2018 он 08 сарын 30 өдөр
Дугаар № 07/43

Монголын Хөрөнгийн
Бирж-д

Тайлбар хүргүүлэх тухай :

Санхүүгийн Зохицуулах хорооны 2018 оны 8 дугаар сарын 29-ны 5/3504 тоот “Үүрэг даалгавар өгөх тухай” албан бичгийг хавсралтаар хүргүүлж байна.

Хавсралт: Санхүүгийн Зохицуулах хорооны 5/3504 тоот албан бичиг

ХҮНДЭТГЭСЭН,
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ



Ш.ЭНХМЭНД

Утас: 99968989,70112166
Цахим хаяг: bumbataitai_21@yahoo.com
Хаяг: 41 тоот, 4-р хороо 16/4 байр
Чингэлтэй дүүрэг Улаанбаатар хот
Монгол Улс



“БУМБАТ-АЛТАЙ ҮЦК” ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Ш.ЭНХМЭНД-Д

САНХҮҮГИЙН БОХИОНСНААУ
ХӨРӨӨ

15110, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Баян тойруу 3, Электронгийн Тү Баяр
Утас: 26-44-44, Факс: (978-11) 32-90 34
E-mail: info@fmc.mn, www.fmc.mn

2018.08.29 № 5/3504

БАНГАД: _____ -НИЙ № _____

Үүрэг даалгавар өгөх тухай

“Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргаж буй энгийн хувьцаанд хөрөнгө оруулахаар төлөвлөж буй стратегийн хөрөнгө оруулагчдын хүрээнд шинээр гадаад, дотоодын хөрөнгө оруулагчдаас саналууд ирсэн тул хамтын ажиллагааг эхлүүлэхэд анхны төлөвлөсөн хугацааг сунгах тухай танай 2018 оны 8 дугаар сарын 24-ний өдрийн 08/39 тоот албан бичигтэй танилцлаа.

Хорооноос үнэт цаасны зах зээлд шинэ төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг дэмжих, урт хугацааны хөрөнгө оруулалтыг хөрөнгийн зах зээлээс татан төвлөрүүлэх боломжийг бүрдүүлэх зорилгоор 2018 оны 6 дугаар сарын 29-ний өдрийн 262 дугаар тогтоолоор “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгэхээр шийдвэрлэсэн болно.


Нэмж гаргасан үнэт цаасыг бүртгэсэн Хорооны 2018 оны 262 дугаар тогтоолын 6 дугаар хэсэгт андеррайтерийн компани татан төвлөрүүлэх хөрөнгийн доод хэмжээг хангах чиглэлээр дээд зэргийн хүчин чармайлт гарган анхдагч зах зээлд арилжих үйл ажиллагааг зохион байгуулах, арилжигдаагүй үнэт цаасыг өөрийн хөрөнгөөр худалдан авахыг андеррайтерийн үйлчилгээ үзүүлсэн танай компанид үүрэг болгосон.

Иймд “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болгох чиглэлээр стратегийн хөрөнгө оруулагчдын хөрөнгийг 2018 оны 8 дугаар сарын 28-ны өдрөөс 2018 оны 9 дүгээр сарын 10-ны өдрийн хугацаанд буюу 14 хоногийн дотор татах, энэхүү хугацаанд хөрөнгө оруулагчдаас хувьцаа худалдан авахаар төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөтэй холбоотой гарах эрсдэлийг андеррайтерийн компанийн бүхэлд нь хариуцан ажиллаж, стратегийн хөрөнгө оруулагчдын хөрөнгийг татаж, анхдагч зах зээлийн арилжааг амжилттай болсон талаар тайланг Хороонд ирүүлэхийг мэдэгдье.

Хэрэв заасан хугацаанд стратегийн хөрөнгө оруулагчаас шаардлагатай хөрөнгийг татан төвлөрүүлж чадаагүй тохиолдолд “Хөвсгөл алтан дуулга” ХК-ийн нэмж гаргасан үнэт цаасыг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлээс хасах ба үүнээс үүсэх эрсдэлийг андеррайтерийн компани хариуцан ажиллахыг анхааруулж байна.

Хувийг: "ҮЦТХТ" ХХК, "Арилжааны төлбөр тооцоо" ХХК, Хөвсгөл алтандуулга
ХК-д

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗРЫН ДАРГА



Б.ЛХАГВАСҮРЭН